

Зам, тээврийн сайдын
20. . . оны . . . дугаар сарын . . . -ны өдрийн
. . . дүгээр тушаалын ... дүгээр хавсралт

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН МЭРГЭЖИЛТЭЙ АЖИЛТАН СУРГАХ, ДАВТАН СУРГАХ, МЭРГЭШҮҮЛЭХ, МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ БОЛОН ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН ЖОЛООДОХ ЭРХ ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН МЭРГЭЖИЛТЭЙ АЖИЛТАН СУРГАХ, ДАВТАН СУРГАХ, МЭРГЭШҮҮЛЭХ, МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ

1.1. Нийтлэг үндэслэл

1.1.1. Энэхүү журмаар төмөр замын салбарын мэргэжилтэй ажилтан сургах, давтан сургалт явуулах, мэргэшүүлэх, шалгалт авах, мэргэшлийн зэрэг олгох, хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрх олгох, хяналт тавих, сургалтын тогтолцоотой холбоотой харилцааг зохицуулна.

1.1.2. Энэхүү журамд ашигласан нэр томъёог Төмөр замын тээврийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд заасан утгаар ойлгоно.

1.1.3. Төмөр замын мэргэжил гэж төмөр замын тээвэрлэлт болон түүнд зориулагдсан суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, салбар зам, бусад байгууламж, тоног төхөөрөмж бүхий үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээний иж бүрдлийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, чадвар, дадлын цогцыг ойлгоно.

1.1.4. Төмөр замын салбарын мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, сургалт зохион байгуулах, шалгалт авах үйл ажиллагааг Төмөр замын тээврийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль болон энэхүү журмаар зохицуулна.

1.1.5. Төмөр замын мэргэжлийн дээд боловсролтой мэргэжилтнийг мэргэшүүлэх, мэргэшлийн зэрэг олгохтой холбоотой харилцаа, сургалтын тогтолцоог энэхүү журам болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

1.1.6. Төмөр замын тээврийн асуудал хариуцсан Төрийн захиргааны байгууллагад орон тооны бус “Төмөр замын дэд салбар зөвлөл” байх бөгөөд уг зөвлөл нь “Зам, тээврийн мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын салбар зөвлөл”-ийн бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаж, уялдаж ажиллана.

1.1.7. Төмөр замын мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг гүйцэтгэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн боловсролыг эзэмшүүлэх түвшнийг дараах байдлаар ангилна.

1.1.7.1. Мэргэжлийн сургалт;

1.1.7.2. Мэргэжлийн болон техникийн боловсрол олгох;

1.1.7.3. Төмөр замын мэргэшлийн зэрэг олгох, ахиулах сургалт;

1.1.7.4. Мэргэшсэн болон зөвлөх инженерийн сургалт.

1.2. Төмөр замын тээврийн мэргэжилтэй ажилтанд сургалт явуулах, шалгалт авах

1.2.1. Төмөр замын тээврийн байгууллага нь энэхүү журмын 1.1.7.1-т заасан сургалтыг зохион байгуулах нэгжтэй байх эсхүл эрх бүхий байгууллагатай гэрээний үндсэн дээр хамтран зохион байгуулж болно.

1.2.2. Энэ журмын 1.1.7.2, 1.1.7.3-т заасан сургалтыг мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага зохион байгуулна.

1.2.3. Төмөр замын тээврийн байгууллага нь Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын сургалт-үйлдвэрлэл, дадлагын түшиц газар байна.

1.2.4. Төмөр замын тээврийн байгууллага нь эрх бүхий сургалтын байгууллагатай хамтран техникийн болон мэргэжлийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулж болно.

1.2.5. Төмөр замын тээврийн байгууллага нь мэргэшлийн зэрэг, албан тушаал болон цалингийн шатлал, ажиллах хугацаанд тавигдах шаардлагыг тогтоосон журмыг батлан хэрэгжүүлнэ.

1.2.6. Төмөр замын мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн болон Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмыг үндэслэн төмөр замын мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг боловсруулах бөгөөд төмөр замын дэд салбар зөвлөлийн санал, дүгнэлтийг тусгасан байна.

1.2.7. Төмөр замын мэргэжлийн боловсрол олгох сургалтад эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн, 18 насанд хүрсэн иргэнийг сургана.

1.2.8. Төмөр замын тээврийн байгууллага нь төмөр замын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагатай хамтарч шалгалт авах, үнэлгээ өгөх үйл ажиллагааг зохион байгуулна.

1.2.9. Төмөр замын мэргэжлийн шалгалт авах, үнэлгээ өгөх ажлыг мэргэжлийн шалгалтын ажлын хэсэг зохион байгуулна.

1.2.10. Техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшсэн төгсөгчдөд Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд заасан боловсролын баримт бичиг олгоно.

1.2.11. Төмөр замын тээврийн байгууллага, төмөр замын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага нь төгсөгчийг бүртгэн, сургалттай холбоотой мэдээллийн сан хөтөлж, Архивын тухай хуульд заасан хугацаагаар баримт бичгийг хадгална. Төмөр замын дэд салбар зөвлөлд холбогдох мэдээллийг хагас жил бүр хүргүүлнэ.

1.2.12. Төмөр замын тээврийн байгууллагын ажилтнаас шинэ ажилтны, мэдлэгийн түвшин тогтоох, мэргэжлийн зэрэг олгох, ахиулах шалгалтыг авах, үнэлгээ өгөх ажлыг Төмөр замын тээврийн байгууллагын баталсан журмаар зохион байгуулна.

1.3. Мэргэшсэн болон зөвлөх инженерт мэргэшлийн зэрэг олгох

1.3.1. Төмөр замын салбарын мэргэшсэн болон зөвлөх инженерт мэргэшлийн зэргийг Төмөр замын дэд салбар зөвлөл олгоно.

1.3.2. Төмөр замын дэд салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг төмөр замын тээврийн байгууллага болон холбогдох бусад байгууллагын саналыг үндэслэн, төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага томилно.

1.3.3. Төмөр замын дэд салбар зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүд нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй байна. Дарга нь Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга байна. Бүрэлдэхүүний 70-аас доошгүй хувь нь зөвлөх, мэргэшсэн, мэргэшлийн зэрэгтэй инженер, мэргэжилтэн байна.

1.3.4. Төмөр замын дэд салбар зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна. Хурлаар мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг олгох мэргэшлийн хүрээ, мэргэшлийн зэрэг горилогчдод зориулсан мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, шалгалтын материал, шалгалт авах арга, мэргэшлийн зэрэг олгох, сунгах, цуцлах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

1.3.5. Төмөр замын дэд салбар зөвлөлийн хурал нь 75-аас доошгүй хувийн ирцтэй хуралдаж, шийдвэрийг олонхын саналаар гаргана. Хурлын шийдвэрийг дарга баталгаажуулна.

1.3.6. Төмөр замын дэд салбар зөвлөл нь дор дурдсан эрх, үүрэгтэй. Үүнд:

1.3.6.1. Төмөр замын тээврийн байгууллагын мэргэжилтэнд мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг олгох үйл ажиллагааг Төмөр замын тээврийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

1.3.6.2. Төмөр замын тээврийн байгууллагын мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг олгох үйл ажиллагаа нь салбарын хөгжлийн бодлого, шинэ технологи, инновацийг нэвтрүүлсэн, мэргэшлийн үндэсний шаталсан бүтцэд нийцсэн, тэгш хүртээмжтэй, ашиг сонирхлын зөрчилгүй, шударга байх зарчимд нийцсэн байна.

1.3.6.3. Мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг горилогч мэргэжлийн алдаа, дутагдал, ёс зүйн зөрчил гаргасан нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон бол Төмөр замын дэд салбар зөвлөлийн хурлаар мэргэшлийн зэргийг цуцлах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

1.3.7. Мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг олгох сургалтын байгууллага нь холбогдох хууль тогтоомжийн болон дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1.3.7.1. Сүүлийн 5 жил үйл ажиллагаа нь тогтмол, хэвийн явагдсан байх;

1.3.7.2. Салбарт ижил төрлийн сургалт зохион байгуулж байсан туршлагатай байх;

1.3.7.3. Мэргэшлийн хүрээ бүрээр гаргасан сургалтыг батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөтэй байх;

1.3.7.4. Сургалтын орчин, материаллаг баазтай байх;

1.3.7.5. Багшлах хүний нөөцийн 80-аас дээш хувь нь салбарын эрдэмтэд болон зөвлөх инженер байх;

1.3.7.6. Сургалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн санг бүрдүүлсэн байх.

1.3.8. Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг олгох сургалтын үйл ажиллагааг эрх бүхий сургалтын байгууллагатай гэрээний үндсэн дээр хамтран хэрэгжүүлнэ.

1.3.9. Мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг олгох шалгалтын комиссын бүрэлдэхүүн нь Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөл болон бусад мэргэжлийн байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

1.3.10. Төмөр замын тээврийн байгууллага, төмөр замын сургалтын байгууллага дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1.3.10.1. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан төмөр замын дэд салбар зөвлөлөөр батлуулах;

1.3.10.2. Сургалтыг батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;

1.3.10.3. Сургалтын үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлэх;

1.3.10.4. Сургалтын үйл ажиллагааны тайлан мэдээ, дүгнэлт, үнэлгээг хагас жил тутамд төмөр замын дэд салбар зөвлөлд тайлагнах;

1.3.10.5. Сургалттай холбоотой бичиг баримт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, суралцагчид болон төгсөгчдийн судалгаа, шалгалтын материал, санал хүсэлтийг архивын нэгж болгон 5 жил хүртэл хугацаагаар хадгалах;

1.3.10.6. Төмөр замын мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад олон улсын дэвшилтэд арга, технологийг нэвтрүүлэн ажиллах;

1.3.10.7. Төмөр замын салбарын хөгжил, Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, төсөл, төлөвлөгөөг боловсруулах талаар сургалтын хөтөлбөрт тусгах;

1.3.11. Мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг олгох, сунгах үйл ажиллагааг зохион байгуулахдаа мэргэжил дээшлүүлэх тогтолцооны бүдүүвч, мэргэшлийн зэрэг олгох, мэргэжилтэнд тавигдах шаардлагыг мөрдлөг болгоно. Мэргэжлийн чиглэлээр докторын зэрэг хамгаалсан тохиолдолд зөвлөх инженерийн зэрэг горилогчийн бичгээр уламжилсан хүсэлтийг үндэслэн зөвхөн мэргэшлийн шалгалтаас чөлөөлж, судалгаа, төсөл хамгаалсны дараа олгох ба 2 удаа сунгасны дараа зэргийг хугацаагүй олгоно.

1.3.12. Төмөр замын салбарын мэргэжилтний суурь мэргэжил, мэргэжлийн мэдлэг ур чадвар, туршлагын үнэлгээнээс хамааруулан дараах хүрээнд мэргэшсэн болон зөвлөх гэсэн шатлал бүхий мэргэжлийн зэрэг олгоно. Үүнд:

- 1.3.12.1. Төмөр замын автоматик ба телемеханик холбоо;
- 1.3.12.2. Зүтгүүр, зүтгүүрийн аж ахуй;
- 1.3.12.3. Вагон, вагоны аж ахуй;
- 1.3.12.4. Төмөр замын барилга, зам, замын аж ахуй;
- 1.3.12.5. Төмөр замын машин ашиглалт;
- 1.3.12.6. Төмөр замын тээврийн инженерчлэл;
- 1.3.12.7. Төмөр замын тээврийн удирдлага, зохион байгуулалт.

1.3.13. Мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг горилогч нь сургалт эхлэхээс 30 хоногийн өмнө дараах баримт, бичгийг бүрдүүлж, эрх бүхий сургалтын байгууллагад цахимаар ирүүлнэ. Үүнд:

- 1.3.13.1. Өргөдөл;
- 1.3.13.2. Ажил байдлын тодорхойлолт;
- 1.3.13.3. Мэргэжлийн дипломын баталгаажсан хуулбар;
- 1.3.13.4. Өмнө нь мэргэжил дээшлүүлсэн талаарх үнэмлэх, гэрчилгээний хуулбар;
- 1.3.13.5. Бүтээлийн тайлан. /Ажил олгогчоос гадна тухайн мэргэжлийн чиглэлээр зөвлөх, мэргэшсэн инженерийн зэрэгтэй 2-оос доошгүй мэргэжилтнээр баталгаажуулсан байна. Тайланд боловсруулсан норм, дүрэм, стандарт, бичсэн ном, гарын авлага, нийтлэл, бүтээлийн фото хэлбэр, нүүр хуудас, гэрчилгээний хуулбар, төсөл, судалгааг гүйцэтгэхэд боловсруулахад ашигласан баримт бичиг, төсвийн талаарх материалуудыг хавсаргана./

1.3.14. Энэнхүү журмын 1.3.13-т заасан холбогдох баримт бичгийг үнэн зөв болохыг баталгаажуулагч этгээд хариуцна.

1.3.15. Зөвлөх инженерийн зэргийг эхний удаа 5 жилээр олгож, шаардлага хангасан тохиолдолд 5 жилээр сунгах ба зохих шалгуурыг хангасан бол 3 дахь сунгалтаас хугацаагүй олгоно.

1.3.16. Мэргэшсэн инженерийн зэргийг эхний удаа 3 жилээр олгож, шаардлага хангасан тохиолдолд 3 жилээр сунгах ба зохих шалгуурыг хангасан бол 3 дахь сунгалтаас хугацаагүй олгоно.

1.3.17. Төмөр замын дэд салбар зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу мэргэшсэн, зөвлөх инженерийн зэргийг 1-2 жил хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно. Хэрэв мэргэжлийн зэргийг түдгэлзүүлэх хугацаа дуусгавар болсон тохиолдолд дэд зөвлөлд мэргэшлийн зэрэг сэргээх хүсэлтээ гаргана.

1.3.18. Мэргэшлийн зэрэг цуцлуулсан, түдгэлзүүлсэн мэргэжилтэн Төмөр замын дэд салбар зөвлөлд гэрчилгээ, баталгааны тэмдгийг хураалгана.

1.3.19. Бүтээл худал мэдүүлсэн, бусдын бүтээлийг ашигласан нь тогтоогдвол мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг олгохоос татгалзах, олгосон зэргийг хүчингүй болгож, хураах үндэслэл болно.

ХОЁР. ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН ЖОЛООДОХ ЭРХ ОЛГОХ

2.1 Зүтгүүр жолоодох эрхийн үнэмлэх олгох

- 2.1.1 Зүтгүүрийн жолоодох эрх олгох шалгалтыг төмөр замын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын дэргэдэх орон тооны бус “Төмөр замын дэд салбар зөвлөл” (цаашид “Төмөр замын дэд салбар зөвлөл” гэх)-өөс хагас жил тутам зохион байгуулж, эрхийн үнэмлэх олгоно.
- 2.1.2 Зүтгүүр жолоодох эрх олгож буй үнэмлэх нь зөвхөн тухайн төмөр замын байгууллагын суурь бүтэц дээр ашиглагдаж буй бүх серийн илчит тэргийг жолоодоход хүчинтэй байна.
- 2.1.3 Зүтгүүрийн туслах машинчийг тухайн төмөр замын байгууллага өөрийн дотоод дүрэм, журмын хүрээнд холбогдох сургалтанд хамрагдаж, шаардлага хангаж буй иргэдээс сонгон шалгаруулж, томилно.
- 2.1.4 Зүтгүүрийн машинчаар ажиллах сонирхолтой, техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшсэн, энэхүү журмын 1.2.7 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаж буй тухайн төмөр замын байгууллагад туслах машинчаар 30000 км-ээс багагүй зайд аялсан эсвэл сэлгээний ажилд туслах машинчаар 2 жилээс багагүй хугацаагаар ажилласан иргэдээс ерөнхий мэдлэгийн шалгалт авч, тэнцсэн тохиолдолд зүтгүүр жолоодох эрхийн үнэмлэх олгоно.
- 2.1.5 Зүтгүүрийн туслах машинч нараас хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрхийн үнэмлэх олгох онолын шалгалтыг Төмөр замын дэд салбар зөвлөлөөс томилсон бүрэлдэхүүнд дор дурдсан сэдвээр өгч, нийт асуултын 80 буюу түүнээс дээш хувийн дүн авсан тохиолдолд зүтгүүр жолоодох эрхийн үнэмлэх авах эрх үүснэ.
 - 2.1.5.1 Төмөр замын техник ашиглалтын дүрэм, Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам, Төмөр замын дохиолол, холбооны журам, хөдөлгөөний ажилд холбогдсон заавар тушаал, журмууд;
 - 2.1.5.2 Тухайн байгууллагын суурь бүтэц дээр ашиглагдаж байгаа бүх серийн зүтгүүрийн хийц, бүтэц, зохион байгуулалт, ашиглалтын болон автомат тоормос ашиглах заавар;
 - 2.1.5.3 Зүтгүүрийн хугацаат үечилсэн засварын дүрэм, замд тохиолдож болох гэмтэл илрүүлэн засварлах, гэмтлээс урьдчилан сэргийлэх арга барил;
 - 2.1.5.4 Дизелийн түлш, түүний үндсэн үзүүлэлт, ашиглаж зарцуулах, арчих тослох материалын тухай хэмнэх арга барил;
 - 2.1.5.5 Зүтгүүрийн бригадын хөдөлмөр хамгаалал, аюулгүйн техникийн дүрэм;
 - 2.1.5.6 Зүтгүүрийн бригадын албан үүргийн заавар;

- 2.1.5.7 Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцаа, нөхцөл, сахилгын тусгай журам, байгууллагын дотоод журам;
- 2.1.6 Хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрхийн үнэмлэх олгох шалгалт авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд дараах ажилтнууд оролцоно. Үүнд:
- 2.1.6.1 Ажлын хэсгийн дарга –Төмөр замын дэд салбар зөвлөлийн дарга эсвэл түүний томилсон төлөөлөл;
- 2.1.6.2 Нарийн бичгийн дарга - Төмөр замын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын зүтгүүрийн асуудал хариуцсан мэргэжилтэн;
- 2.1.6.3 Төмөр замын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагын Төмөр замын бодлого зохицуулалтын газрын төлөөлөл;
- 2.1.6.4 Төмөр замын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын зүтгүүр, зам, дохиолол холбоо хариуцсан байцаагч болон зүтгүүрийн асуудал хариуцсан мэргэжилтэн;
- 2.1.6.5 Тухайн төмөр замын байгууллагын төлөөлөл.
- 2.1.7 Онолын шалгалтын актанд Ажлын хэсгийн дарга, гишүүд гарын үсгээ зурсан байна.
- 2.1.8 Зүтгүүр жолоодох эрхийн үнэмлэх олгох онолын шалгалтад орох туслах машинчид дор заасан бичиг баримт бүрдүүлсэн байна.
- 2.1.6.1 Техникийн, мэргэжлийн болон дээд боловсролын дипломын хуулбар хувь;
- 2.1.6.2 Туслах машинчаар аялсан километр, ажилласан жилийн тодорхойлолт;
- 2.1.6.3 Машинчийн мэргэжлийн ажилд эрүүл мэндээр тэнцэх тухай эрүүл мэндийн үзлэг хийсэн актын хуулбар;
- 2.1.9 Төмөр замын дэд салбар зөвлөлөөс олгосон зүтгүүр жолоодох эрхийн үнэмлэх нь зөвхөн тухайн төмөр замын байгууллагын суурь бүтэц дээр хүчинтэй байна.
- 2.1.10 Тухайн байгууллагын зүтгүүр жолоодох эрх авсан этгээд бусад төмөр замын байгууллагад шилжин шинэ маягийн зүтгүүр жолоодох тохиолдолд дахин шалгалт өгч, зүтгүүр жолоодох эрхийн үнэмлэх авна.
- 2.1.11 Зүтгүүр жолоодох эрхийн үнэмлэхийг 5 жилийн хугацаатайгаар олгоно.

2.1.12 Тухайн төмөр замын байгууллагын зүтгүүрийн паркийн 50-аас дээш хувьд өөрчлөлт орж, шинэ серийн илчит тэрэг ашиглах тохиолдолд тухайн төмөр замын байгууллагын зүтгүүр жолоодох эрх авсан машинч нар дахин шалгалтанд хамрагдана.

2.1.13 Шалгалт болон үнэмлэхтэй холбогдон гарах зардлын хэмжээг Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар батлах бөгөөд шалгалт өгөх этгээд уг төлбөрийг төлнө.

ГУРАВ. ЗҮТГҮҮРИЙН МАШИНЧ НАРТ МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ

3.1. Зүтгүүрийн машинч нар онолын мэдлэг, ажлын ур чадвар, дадлага туршлага, хувийн сахилга, хариуцлагаас шалтгаалан мэргэшлийн зэрэггүй болон зэрэгтэй байх бөгөөд мэргэшлийн зэргийг дараах байдлаар ангилна:

3.1.1. Нэгдүгээр зэргийн машинч;

3.1.2. Хоёрдугаар зэргийн машинч;

3.1.3. Гуравдугаар зэргийн машинч;

3.1.4. Дөрөвдүгээр зэргийн машинч.

3.2. Хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрхийн үнэмлэх авсан туслах машинчийг 3-аас багагүй сар зааварлагч машинчийн удирдлагад зүгшрүүлэх аялал хийсний дараа ачааны галт тэрэг жолоодох, сэлгээний зүтгүүрт машинчаар ажиллуулах зөвшөөрлийг тухайн төмөр замын байгууллагаас олгоно.

3.3. Зүтгүүрийн машинчид мэргэшлийн зэрэг болон нэмэгдэл цалин олгох асуудлыг тухайн төмөр замын байгууллага дотоод дүрэм, журмаар зохицуулж, хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ БУУРУУЛАХ, ЗҮТГҮҮР ЖОЛООДОХ ЭРХИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

4.1 Зүтгүүр жолоодох эрхийг машинчийн гаргасан зөрчилтэй холбогдуулан тухайн төмөр замын байгууллагаас гаргасан хүсэлт эсхүл Улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн Төмөр замын дэд салбар зөвлөл хүчингүй болгоно.

4.2 Мэргэшлийн зэрэг бууруулах асуудлыг тухайн төмөр замын байгууллага дотоод дүрэм, журмаар зохицуулж, хэрэгжүүлнэ.

4.3 Хориглосон заалттай дохио өнгөрсөн, ажилдаа согтуу ирэх, галт тэрэгний хөдөлгөөнд сүйрэл, осол гаргасан, их хэмжээний хохирол учруулсан машинч, туслах машинч нарын хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрхийн үнэмлэхийг хууль тогтоомжид зааснаар хурааж, холбогдох нотлох баримтыг хавсарган Төмөр замын дэд салбар зөвлөлд хүргүүлж, хүчингүй болгох тухай шийдвэр гаргуулна.

ТАВ. ЗҮТГҮҮР ЖОЛООДОХ ЭРХИЙН ҮНЭМЛЭХ ДАХИН ОЛГОХ

- 5.1 Төмөр замын дэд салбар зөвлөлийн тогтоолоор зүтгүүр жолоодох эрхийн үнэмлэхээ хүчингүй болгуулсан иргэн дахин үнэмлэхээ авахдаа энэхүү журмын 2 дугаар бүлэгт заасны дагуу дахин шалгалтанд хамрагдана.
- 5.2 Хүчин төгөлдөр зүтгүүр жолоодох эрхийн үнэмлэхээ алдаж үрэгдүүлсэн тохиолдолд Төмөр замын дэд салбар зөвлөлд энэ талаар мэдэгдэж, хэвлэлд зарлуулсны дараагаар зүтгүүр жолоодох эрхийн үнэмлэхийг дахин олгоно.
- 5.3 Зүтгүүр жолоодох эрхийн үнэмлэхийг дахин авах хүртэл хугацаанд туслах машинчаар түр хугацаагаар ажиллуулна.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

--- o0o ---

Зам, тээврийн сайдын
20. . . оны . . . дугаар сарын . . . -ны өдрийн
. . . дүгээр тушаалаар баталсан
“Төмөр замын тээврийн салбарын мэргэжилтэй
ажилтан сургах, давтан сургах, мэргэшүүлэх,
мэргэшлийн зэрэг болон хөдлөх бүрэлдэхүүн
жолоодох эрх олгох журам”-ын нэгдүгээр хавсралт

ТӨМӨР ЗАМЫН МЭРГЭЖИЛТЭЙ АЖИЛТАН АЖИЛЛАХ АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

Нэг. Төмөр замын тээврийн байгууллага түүний газар, алба, тасаг, хэлтэс, салбар, нэгжийн дараах албан тушаалд төмөр замын их, дээд сургууль, коллежийн бакалаврын болон түүнээс дээш сургалтаар дээд боловсрол эзэмшсэн иргэн ажиллана. Үүнд:

- 1.1. Дарга, захирал /ТУЗ томилдогоос бусад/ Төмөр замын үндсэн мэргэжлийн нэгжийн дарга, орлогч дарга, дэд захирал, ерөнхий инженер;
- 1.2. Инженер, менежер, мэргэжилтэн /төмөр замын бүх төрлийн/;
- 1.3. Ерөнхий механикч;
- 1.4. Зааварлагч /автотоормосын, дулааны техникийн, вагоны үйлчлэгчийн/;
- 1.5. Дохиолол, холбооны засвар, үйлчилгээний төвийн дарга;
- 1.6. Суурь бүтэц хариуцсан инженер-механикч /дохиолол холбооны, замын/;
- 1.7. Засварын хүлээн авагч /вагон, зүтгүүрийн депогийн/;
- 1.8. Зам хэмжигч, сэв шалгагч, тосолгооны вагоны дарга;
- 1.9. Галт тэрэгний ахлах диспетчер, галт тэрэгний диспетчер /үндсэн мэргэжлийн/;
- 1.10. Техник үзлэгийн газрын дарга;
- 1.11. Засварын цехийн дарга /вагон, зүтгүүрийн депогийн/;
- 1.12. Галт тэрэгний дарга;
- 1.13. Инженер-эдийн засагч /бүх шатны нэгжийн төлөвлөгөө, санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан/;
- 1.14. Зураг төсөл судалгааны байгууллагын төмөр замын зам барилгын зураг төслийн инженер;
- 1.15. Төмөр замын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх сургуулийн мэргэжлийн багш;
- 1.16. Төмөр замын тодорхой чиглэлийн болон аюулгүй байдал хариуцсан хяналтын байцаагч.

Хоёр. Төмөр замын тээврийн байгууллага, түүний газар, алба, тасаг, хэлтэс, салбар нэгжийн дараах албан тушаалд төмөр замын их дээд сургууль, түүнтэй адилтгах түвшний сургуулийн дипломын сургалтаар дээд боловсрол эзэмшсэн, бүх төрлийн техникч ажиллана. Үүнд:

- 2.1. Техникч /бүх төрлийн/;
- 2.2. Зааварлагч-машинч;
- 2.3. Техникийн үзлэгийн хүлээн авагч-машинч;

- 2.4. Тууз орчуулагч;
- 2.5. Сэргээн босгохын болон усны галт тэрэгний дарга;
- 2.6. Мастер /үндсэн мэргэжлийн/;
- 2.7. Вагон хуваарилагч;
- 2.8. Өртөө, зөрлөгийн дарга /аж ахуйн тооцоотой бие даасан нэгжээс бусад/;
- 2.9. Өртөөний жижүүр /ангигүй, I зэрэгтэй/;
- 2.10. Ачааны зохицуулагч /диспетчер/;
- 2.11. Тооцооны төв /хэсэг/-ийн эрхлэгч;
- 2.12. Тасалбар, тээшийн орлогын нярав /суурин, явуулын/;
- 2.13. Тооцооны оператор /ахлах/, тооцооны оператор-тасалбарын нярав;
- 2.14. Өртөөний жижүүрийн оператор;
- 2.15. Сэлгээний /диспетчер/, довын жижүүр;
- 2.16. Дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын механикч;
- 2.17. Сэв шалгагч, үл эвдэх шалгуурын опетаор;
- 2.18. Зам барилга, засварын машин механизмын механикч, машинч;
- 2.19. Үе угсрах газрын механикч, мастер;
- 2.20. Технологийн холбооны механикч;
- 2.21. Радио холбооны механикч;
- 2.22. Зааварлагч /үндсэн бүх мэргэжлийн/.

Гурав. Төмөр замын тээврийн байгууллага, түүний газар, алба, тасаг, салбар нэгжийн дараах албан тушаалд мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад төмөр замын тээврийн, үйлчилгээний, үйлдвэрлэлийн чиглэлээр мэргэжлийн боловсрол эзэмшсэн иргэн ажиллана. Үүнд:

- 3.1. Зүтгүүрийн депогийн ээлжийн жижүүр-машинч, туслах жижүүр;
- 3.2. Зүтгүүрийн машинч туслах машинч;
- 3.3. Засварчин /зүтгүүрийн болон вагоны/;
- 3.4. Вагоны үйлчлэгч;
- 3.5. Вагон үзэгч;
- 3.6. Галт тэрэгний найруулагч;
- 3.7. Өртөөний туслах жижүүр;
- 3.8. Замчин /3-аас дээш зэрэгтэй/;
- 3.9. Зам барилга, засварын машин механизмын оператор, туслах машинч;
- 3.10. Дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын механикч;
- 3.11. Билет, бараа, тээшийн тасалбар бичигч;
- 3.12. Агент /ахлах/;
- 3.13. Ачаа вагон хүлээлцэгч /ахлах/.

Дөрөв. Төмөр замын тээврийн байгууллага, түүний газар, алба, тасаг, хэлтэс, салбар нэгжийн дараах албан тушаалд мэргэжлийн “Чадамжийн гэрчилгээ”-тэй ажиллана. Үүнд:

- 4.1. Зөрлөгийн жижүүр
- 4.2. Галт тэрэгний туслах найруулагч;
- 4.3. Замчин /1-2 дугаар зэрэгтэй/;
- 4.4. Техникийн конторчин, вагон бичигч;
- 4.5. Засварчин;
- 4.6. Зорчигчийн вагоны үйлчлэгч
- 4.7. Дохиолол, холбоо, эрчим хүчний монтёр

Тав. Галт тэрэгний ба сэлгээний хөдөлгөөнд шууд холбоотой ажил албан тушаалын жагсаалт. Үүнд:

- 5.1. Төмөр замаар өөрөө явагч хөдлөх бүрэлдэхүүний машинч, туслах машинч;
- 5.2. Өртөөний дарга, орлогч дарга, жижүүр, туслах жижүүр;
- 5.3. Өртөөний туслах жижүүр;
- 5.4. Зөрлөгийн дарга жижүүр;
- 5.5. Зүтгүүрийн депогийн ээлжийн жижүүр-машинч, туслах жижүүр;
- 5.6. Диспетчер /ялгах довын, зүтгүүрийн, сэлгээний, ачааны/;
- 5.7. Довын жижүүр;
- 5.8. Вагон бичигч, техникийн конторчин;
- 5.9. Галт тэрэгний диспетчер, галт тэрэгний ахлах диспетчер;
- 5.10. Вагон , чингэлгийн засвар, үйлчилгээний оператор;
- 5.11. Хөдлөх бүрэлдэхүүний салгалтгүй зсварын мастер, засварчин;
- 5.12. Вагон үзэгч /ахлах/, вагон үзэгч засварчин /ахлах/;
- 5.13. Галт тэрэгний найруулагч, туслах найруулагч;
- 5.14. Дохиочин;
- 5.15. Сумчин, сум цэвэрлэгч;
- 5.16. Ивүүрчин;
- 5.17. Сэргээн босгон болон усны галт тэрэгний мастер;
- 5.18. Зорчигчийн галт тэрэгний дарга, мастер;
- 5.19. Зорчигчийн болон тусгай зориулалтын вагоны үйлчлэгч;
- 5.20. Зорчигчийн галт тэрэгний дарга, мастер;
- 5.21.Зорчигчийн болон тусгай зориулалтын вагоны үйлчлэгч;
- 5.22. Хөргүүрт вагоны мастер;
- 5.23. Замын дээд, доод бүтцийн засвар, арчилгаа болон хяналтын бригадын дарга;
- 5.24. Зам барилга, засварын машин механизмын инженер-механикч, машинч
- 5.25. Замын ахлах мастер, мастер;
- 5.26. Гүүрийн мастер;
- 5.27. Хянах, хэмжих вагон /сэв шалгагч, зам, хэмжигч/-ын тохируулагч;
- 5.28. Зам хэмжүүрийн оператор, тууз орчуулагч;
- 5.29. Сэв шалгагч, тэргэнцэрийн оператор;
- 5.30. Зам засварын чанарын хүлээн авагч;
- 5.31. Гармын жижүүр;
- 5.32. Замчин;
- 5.33. Тор засагч;
- 5.34. Дохиоллын төхөөрөмж, аппаратын засварчин, монтёр;
- 5.35. Дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын инженер, механикч, монтёр;
- 5.36. Ачаа вагон хүлээлцэгч;
- 5.37. Агент;
- 5.38. Авто тоормосын зааварлагч, машинч;
- 5.39. Зам төмөр шавагч;
- 5.40. Зам төмрийн гагнуурчин;
- 5.41. Цахилгаан механик, монтёр;
- 5.42. Технологийн холбооны инженер, механикч, монтёр;
- 5.43. Радио, холбооны инженер, механикч, монтёр;
- 5.44. Хүлээн авах пүүлэгч.

Зургаа. Энэхүү журмын хавсралтын 4-т заасан албан тушаал, мөн гармын жижүүр, сумчин, тор засагч, сум цэвэрлэгч дохиочин зэрэг албан тушаалд мэргэжлийн бус ажилтанг дагалдуулан ажиллуулж байх хугацаанд холбогдох шалгалтанд хамруулж мэргэжлийн зэрэг, чадамжийн гэрчилгээ олгоно.

---oOo---

Зам, тээврийн сайдын
20. . . оны . . . дугаар сарын . . . -ны өдрийн
. . . дүгээр тушаалаар баталсан
“Төмөр замын тээврийн салбарын мэргэжилтэй
ажилтан сургах, давтан сургах, мэргэшүүлэх,
мэргэшлийн зэрэг болон хөдлөх бүрэлдэхүүн
жолоодох эрх олгох журам”-ын хоёрдугаар хавсралт

МЭРГЭШСЭН БОЛОН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕРИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ГОРИЛОГЧИД ТАВИХ ШААРДЛАГА

Мэргэжил		Мэргэшлийн зэрэг олгох мэргэжилтэнд тавигдах шаардлага	Мэргэшлийн зэрэг олгох шалгаруулалтын үйл ажиллагааны үе шат	Мэргэжилтэн мэргэшлийн зэргийг горилох, сунгах, цуцлах үе шат
МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР	БОЛОВСРОЛ	Төрөөс баримтлах боловсролын стандартыг хангасан их, дээд сургууль төгсөж бакалаврын боловсрол эзэмшсэн байх	1. Мэргэжилтний бүтээл туршлагыг загварын дагуу гаргасан бүтээлийн тайланг хянан магадлан үнэлэх. 2. Салбарын мэргэжлийн сэтгүүл, хэвлэлд асуудал дэвшүүлсэн өгүүлэл, мэргэжлийн холбогдолтой зүйл 1-ээс доошгүй бичсэн байх.	Зэргээ сунгуулах хүсэлтийг зэрэг авснаас хойших хугацаанд хийсэн ажил болон мэргэжил дээшлүүлсэн талаарх тайлан, байгууллагын тодорхойлолтын хамт зэргийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө Төмөр замын дэд салбар зөвлөлд ирүүлнэ. Мэргэшсэн инженерийн зэргийн хугацааг сунгахдаа:
	АЖИЛЛАСАН ЖИЛ	Төмөр замын мэргэжлийн бакалавр зэрэгтэй бол 5-аас дээш жил мэргэжлээрээ тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх, гүйцэтгэгч байгууллагад тогтвортой 4 жил ажилласан байх	3. Мэргэжлийн талаар гарын авлага боловсруулах. 4. Мэргэжлийн болон ур чадварын шалгалт нь мэргэжлийн мэдлэг ур чадварыг шалгах тест байх ба авбал зохих нийт онооны 85 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд	• Өөрийн биеэр ирж бүтээлээ шалгалтын комисст тайлагнана. • Мэргэжлийн чиглэлээрээ 1-ээс доошгүй хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандарт боловсруулахад заавал оролцсон, хянан тохиолдуулсан, санал өгч тусгуулсан, заавар зөвлөмж, гарын авлага гаргасан байх.

		Төмөр замын мэргэжлийн магистрын зэрэгтэй бол 4-өөс дээш жил мэргэжлээрээ тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх, гүйцэтгэгч байгууллагад тогтвортой 3 жил ажилласан байх	тэнцсэнд тооцно.	Мэргэшсэн инженерийн зэрийн хугацаа сунгахад биеэр ирж бүтээлээ шалгалтын комисст тайлагнах ба 85 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд сунгана.
ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР	БОЛОВСРОЛ	Төрөөс баримтлах боловсролын стандартыг хангасан их, дээд сургууль төгсөж бакалаврын боловсрол эзэмшсэн байх	1. Мэргэжилтний бүтээл туршлагыг загварын дагуу гаргасан бүтээлийн тайланг хянан магадлан үнэлэх. 2. Мэргэжлийн болон ур чадварын шалгалт нь мэргэжлийн /салбарын хууль, эрх зүйн баримт бичиг, норм, норматив, стандарт, дүрэм, журам, заавар/ мэдлэг, ур чадварыг шалгах тест байх ба авбал зохих онооны 90 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд тэнцсэнд тооцно. 3. Сонгосон буюу	Зэргээ сунгуулах хүсэлтийг зэрэг авснаас хойших хугацаанд хийсэн ажил болон мэргэжил дээшлүүлсэн талаарх тайлан, байгууллагын тодорхойлолтын хамт зэргийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө сургалтын байгууллагад ирүүлнэ. Зөвлөх инженерийн зэргийн хугацааг сунгахдаа: Мэргэшлийн зэрэг сунгах сургалтын багц цагийн 70 хувьд суусан байна. Өөрийн биеэр ирж бүтээлээ шалгалтын комисст тайлагнана. Мэргэшсэн инженерийн зэргээ зөвлөх зэрэгт
	АЖИЛЛАСАН ЖИЛ	Мэргэшсэн инженерийн зэрэг авснаас хойш мэргэжлээрээ 9 ба түүнээс дээш жил тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх		

	БУСАД ШААРДЛАГА	Мэргэжлийн хүрээний чиглэлээр доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан тохиолдолд Зөвлөх зэрэг горилогчийн бичгээр уламжилсан хүсэлтийг үндэслэн зөвхөн мэргэжлийн шалгалтаас чөлөөлөх	оноож өгсөн сэдвээр реферат бичиж, хамгаалан Төмөр замын дэд салбар зөвлөлийн гишүүдийн 80 ба түүнээс дээш хувийн санал авсан тохиолдолд тэнцсэнд тооцно. 4. Төмөр замын салбарын холбогдолтой эрдэм, шинжилгээ, судалгаа, инновацын чиглэлээр 3-аас доошгүй материал салбарын хэвлэлд нийтлүүлсэн байх.	ахиулахдаа: • Мэргэшсэн инженерийн зэргээ зөвлөх зэрэгт ахиулах хүсэлт гаргасан бол зэрэг сунгах бүтээлээрээ тайлан хамгаалалтад орж тэнцсэн байна. • Мэргэжлийн ур чадварын мэдлэгийг шалгах тестийн шалгалтад авбал зохих онооны 90 буюу түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн байх • Сэдвийн хамгаалалтад томилогдсон шалгалтын комиссын гишүүдийн 75 буюу түүнээс дээш хувийн санал авсан байна.
--	-----------------	--	--	---